



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/522

Номгон

Ашиглалтын тусгай зөвшөөрөл
эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт
шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бөмбөгөр, Бууцагаан, Баян-Овоо, Галуут, Жаргалант, Өлзийт сумдын нутагт уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглахтай холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулсан ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Мандал)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энжаргал)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

626211327